



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

«Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед хадгаламж, зээлийн хоршоодод авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.13, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2.1.2, УИХ-ын 2020 оны “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” 32 дугаар тогтоолын 2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 145/124 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилал, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 1.3 дахь хэсгийн үйлчлэлийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд түр зогсоосугай.

2. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 145/124 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилал, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын зээлийн ангиллыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл дор дурдсан байдлаар ангилж ажиллахыг нийт хадгаламж, зээлийн хоршооны гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Зээл	30 хоног хүртэл	31-90	91-180	181-360	361-ээс дээш

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



D:\2022\Huraldaan\togtool\blank\02.docx

151800000038